

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ГУЧИНДӨРӨВДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны арваннэгдүгээр сарын 03-ны 14 цаг ... минутад эхэлж, 15 цаг 23 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 08 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Барилга, хот байгуулалтын яамны Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/30 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус ондэслэн:</p> <p>Нямсүрэнгийн Нарантуяаг Барилга, хот байгуулалтын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
2	Зам, тээвэр хөгжлийн яамны Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/31 дүгээр дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр</p>

		<p>03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Сангадоржийн Батболдыг Зам, тээврийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
3	<p>Засгийн газрын тохируулагч агентлаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Харилцаа холбоо, шуудангийн бодлого зохицуулалтын хэлтсийн, Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын хэлтсийн даргын албан тушаалд тус тус томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/32 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Дангаагийн Батбаярыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Харилцаа холбоо, шуудангийн бодлого, зохицуулалтын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/33 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр</p>

		<p>03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Бадамдоржийн Билэгдэмбэрэлийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Мэдээллийн технологийн бодлого, зохицуулалтын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
4	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргын, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын даргын, Хүний нөөц, сургалтын хэлтсийн даргын албан тушаалд тус тус томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/34 дүгээр дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Батжаргалын Бадамцэцэгийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Р.Содхүүд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/34 дүгээр дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг</p>

		<p>тус тус үндэслэн:</p> <p>Дамбажавын Батболдыг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Р.Содхүүд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/36 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Төртогтохын Ганжаргалыг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Р.Содхүүд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
5	Орхон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаал томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	<p>Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга П.Пүрэвлхагвын 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 433 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгыг хэлэлцээд, Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 12 дугаар</p>

		сарын 05-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэв.
6	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх мэргэшлийн шалгалтын дүн	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйл, 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Дундговь аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1.Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 46 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 5 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2.Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан гуравдугаар хавсралтад дурдсан нэр бүхий 5 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан дөрөвдүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 3 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 8 иргэнийг “Нийтийн албанд нийтийн</p>

		<p>болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Дундговь дахь салбар зөвлөл /О.Чулуунбат/-д, үүрэг болгох</p> <p>4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамба даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
7	<p>Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг" Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн батлах Үүнд:</p> <p>Салбар зөвлөлийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шүүхийн захиргааны удирдлагын газрын дарга</li> </ul> <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шүүхийн хүний нөөцийн газрын дарга, Шүүхийн санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга,</li> <li>- Шүүхийн ёс зүйн хорооны Ажлын албаны дарга,</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Дотоод аудитын албаны дарга, Шүүхийн мэдээллийн технологийн хэлтсийн дарга</li> <li>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга</li> <li>- Шүүхийн хүний нөөцийн газрын Ажлын албаны хүний нөөц хариуцсан референт</li> </ul> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 41 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
8	Төрийн албаны зөвлөлийн Зэвсэгт хүчний жанжин штабын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг” мөн Зөвлөлийн 2016 оны 119 дүгээр тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.Төрийн албаны зөвлөлийн Зэвсэгт хүчний жанжин штабын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн батлах Үүнд:</p> <p>Салбар зөвлөлийн дарга</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зэвсэгт хүчний жанжин штабын дарга,</li> </ul> <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албаны зөвлөлийн төлөөлөл,</li> <li>- Зэвсэгт хүчний жанжин штабын орлогч дарга,</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Зэвсэгт хүчний жанжин штабын Тэргүүн ахлагч,</li> <li>- Зэвсэгт хүчний жанжин штабын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга,</li> <li>- Зэвсэгт хүчний ерөнхий хянан шалгагч, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга,</li> <li>- Зэвсэгт хүчний жанжин штабын Ажиллагааны удирдлагын газрын дарга,</li> <li>- Зэвсэгт хүчний жанжин штабын Ар талын газрын дарга,</li> <li>- Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч,</li> <li>- Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч,</li> </ul> <p>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зэвсэгт хүчний жанжин штабын Хүний нөөцийн хэлтсийн дарга</li> </ul> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Хоёр”-ын 5 дахь хэсэг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 8 дахь хэсэг, “Төрийн албан зөвлөлийн Зэвсэгт хүчний жанжин штабын дэргэдэх салбар зөвлөлийн даргыг томилох тухай” 2015 оны 176 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
9	Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны



		<p>зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай ” мөн Зөвлөлийн 2016 оны 119 дүгээр тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн батлах Үүнд:</p> <p>Салбар зөвлөлийн дарга:</p> <ul style="list-style-type: none"><li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга,</li></ul> <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none"><li>- Төрийн албаны зөвлөлийн төлөөлөл,</li><li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга,</li><li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга,</li><li>- Дотоод аюулгүй байдал, хяналт шалгалтын газрын дарга,</li><li>- Тогтоол гүйцэтгэх газрын дарга,</li><li>- Шийдвэр гүйцэтгэх газрын дарга,</li><li>- Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын хэлтсийн дарга,</li><li>- Хүний нөөцийн бодлогын хэлтсийн дарга,</li></ul> <p>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга</p> <ul style="list-style-type: none"><li>- Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн.</li></ul> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Хоёр”-ын 6 дахь хэсэг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 6 дахь хэсэг, “Төрийн албан зөвлөлийн салбар зөвлөлийн даргыг томилж, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” мөн Зөвлөлийн 2015 оны 61, “Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр</p>
--	--	---

		<p>гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилж, тогтоолд өөрчлөлт оруулах тухай тухай” мөн Зөвлөлийн 2015 оны 160 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
10	<p>Зарим албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг, дэв олгуулах тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйл, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг батлах тухай” Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан журмын 2, 6 дахь заалт, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2000 оны 20 дугаар тогтоолын 1-д заасны дагуу төрийн захиргааны албан тушаалын тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар ирүүлсэн саналыг хэлэлцээд, 3 албан хаагчид тэргүүн түшмэлийн, 1 албан хаагчдад эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>
11	<p>Бусад асуудал /Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны даргын, Хууль зүйн яамны харьяа Хууль зүйн туслалцааны төвийн захирлын албан тушаал томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай/</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны даргын, Хууль зүйн яамны харьяа Хууль зүйн туслалцааны төвийн захирлын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэв.</p>

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
АЖЛЫН АЛБА**